



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/240

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6, 7.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн хөгжил” ахмадын зөвлөл, “Шинэ нийгмийн эрүүл мэнд” нийгэмлэгтэй хамтран зохион байгуулах “Эрүүл аж төрөх ёсны мэдлэг, дадал төлөвшүүлэхэд чиглэсэн сургалтын аргачлал, ур чадвар эзэмшүүлэх” сургалтын удирдамж, хөтөлбөрийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулахыг Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба /З.Наранбаатар/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.


ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.НАРАНТУЯА

19

... өдрийн ... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**“ЭРҮҮЛ АЖ ТӨРӨХ ЁСНЫ МЭДЛЭГ, ДАДАЛ ТӨЛӨВШҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН
СУРГАЛТЫН АРГАЧЛАЛ, УР ЧАДВАР ЭЗЭМШҮҮЛЭХ
СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

Сургалтын зорилго:

Иргэдэд эрүүл аж төрөх ёсны мэдлэг, дадал төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг явуулах арга аргачлал, ур чадварыг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд эзэмшүүлэх, сэтгэлд шингэсэн үйлчилгээ үзүүлэх чадварыг сайжруулах

Зорилт:

1. Мэдээлэл, сургалт, сурталчилгааг иргэдэд ойртуулах, үр дүнтэй зохион байгуулах шинэлэг арга аргачлалд суралцах
2. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хүн амд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг хүргэх, үр дүнг тооцох ур чадвар эзэмших
3. Эмнэлгийн мэргэжилтний сэтгэлд хүрсэн үйлчилгээ үзүүлэх хандлага, чадварыг дээшлүүлэх

Сургалтын хамрах хүрээ:

Аймгуудын Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ, хувийн эмнэлэгийн эмч, мэргэжилтнүүд


Сургалтын хугацаа:

2017 оны 11-12-р сар

Хүлээгдэж буй үр дүн:

1. Сургалтад оролцогчид олон нийтийг идэвхжүүлэх мэдээлэл сургалт, сурталчилгаа зохион байгуулах шинэлэг арга зүй, ур чадварт суралцана.
2. Орон нутгийн хэмжээнд олон нийтийг оролцуулсан, тэднийг идэвхжүүлсэн мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах чадвартай эмч, мэргэжилтнүүд бэлтгэгдэнэ.
3. Үйлчлүүлэгчдийн сэтгэлд хүрсэн үйлчилгээ үзүүлдэг болсон эмнэлгийн мэргэжилтний тоо нэмэгдэнэ.

19. өдрийн 12 сарын
А дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



“ЭРҮҮЛ АЖ ТӨРӨХ ЁСНЫ МЭДЛЭГ, ДАДАЛ ТӨЛӨВШҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН
СУРГАЛТЫН АРГАЧЛАЛ, УР ЧАДВАР ЭЗЭМШҮҮЛЭХ
СУРГАЛТЫН ТӨСӨВ

№	Зардлын жагсаалт	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Оролцогчдын бичиг хэрэгслийн зардал	1 хүн	30 ширхэг	2500	75 000
2	Оролцогчдын цайны зардал	1 хүн/өдөр	30 хүн x 6 удаа	2500	450 000
3	Оролцогчдын хоолны зардал	1 хүн/өдөр	30 хүн x 3 удаа	8500	765 000
4	Багшийн цагийн хөлс	Цагаар	24 цаг	25 000	600 000
5	Гэрчилгээний зардал	1 хүн	30 ширхэг	2000	60 000
	Бүгд зардал				1 950 000
	Нийт зардал				1 950 000 төг x 2 удаагийн сургалт = 3 900 000 төг

Хянасан:

Д.Гантуяа /Ахлах нягтлан/

Боловсруулсан: О.Баярсайхан /ЭМАХА-ны мэргэжилтэн/